



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 10

Мандалговь

Төсөл сонгон шалгаруулах хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.17, Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн 42.1.9, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалын хавсралтын 4.2 дахь заалтуудыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь :

1."Хоршоо хөгжүүлэх сан"-гийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

А. Зөвлөлийн дарга : Сумын ЗДТГазрын дарга (Ц.Лхагвасүрэн)

Б. Нарийн бичгийн дарга : сумын ЗДТГ-ын Жижиг дунд үйлдвэр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (Ш.Бямба)

В.Гишүүд : сумын ЗДТГ-ын ХХСангийн ня-бо


Монголыг үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Дундговь салбар хариуцсан менежер (Т.Урансайхан)

Аймгийн Баялаг бүтээгчдийн дэмжих холбооны дэд тэргүүн (С.Өлзийсайхан)

2. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж төслийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулж ажиллахыг хорооны дарга (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

3.Зээл, зээлийн хүүгийн орлогыг хугацаа алдалгүй дансанд төвлөрүүлж сангийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (С.Бат-Оргил)-д хариуцуулсугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ